



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/2/СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: ..... Ч.Ариунаа

Утас: ..... Цахим хаяг: .....

Аудитын менежер: .....

Утас: ..... Цахим хаяг: .....

Ахлах аудитор: .....Ц.Лүндэгмаа

Утас: ..... Цахим хаяг: .....

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	10
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	11
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	12
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	12
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	12
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	13
3	Менежментийн захидал .....	15
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	17

---

## 1 Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2019.03.28 № 1-6/378

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Э.ГАНБАЯР ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэ сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэ сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Эрдэнэ сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийн (54 дүгээр зүйлийн 54.3/26 дугаар зүйлийн 26.1)<sup>7</sup>-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Э.Энхбаяр -д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.15-наас 2019.03.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.03.04-ны өдрийн 03/117 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрдэнэ сумын Засаг дарга талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрдэнэ сумын Засаг дарга нь Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, чанартай шуурхай хүргэх цомхон чадварлаг мэргэжлийн тогтвортой ажлын албыг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Эрдэнэ сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 6 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Эрдэнэ сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

#### Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	5	1			
2	ТБӨӨААН					
	Дүн	5	1			

#### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрдэнэ сумын Засаг дарга мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэ сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрдэнэ сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашиглаагүй байна.

Эрдэнэ сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

#### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрдэнэ сумын Засаг дарга бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2

асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлын 2 хувиар сонгов.

Зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь хөрөнгийн дүн өндөр байсантай холбоотой юм.

Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны нийт зардлын дүн 2,703.7 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 54,073.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Эрдэнэ сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 226.5 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 36.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 9.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв.Үүнд:

### **2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар**

#### **1.Балансын данстай холбоотой асуудал:**

Асуудал 1 Сургууль: Тулган баталгаажуулалт хийж үзэхэд хувийн байгууллага болон төрийн байгууллагад төлбөрийг илүү шилжүүлэн 7806.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоов.

Асуудал 2 Сургууль: Тулган баталгаажуулалт хийж үзэхэд хувийн байгууллага болон төрийн байгууллагад төлбөрийг илүү шилжүүлэн 25468.6 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

**Шийдэл:** Албан шаардлага бичив.

Асуудал 3 Сургууль:Төрийн болон орон нутгийн үндсэн хөрөнгийг холбогдох дээд байгууллагын шийдвэрийг харгалзахгүйгээр данснаас хассан байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгөв.

Асуудал 4 Сургууль: Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг тулган баталгаажуулж үзэхэд нийгмийн даатгалын байгууллагад өгөх өглөгийг 158.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгөв.

Асуудал 5 Соёлын төв:Батлан гаргасан хууль эрхзүйн актуудыг судалдаггүй, үйл ажиллагаандаа мөрдлөг болгодоггүйтэй холбоотойгоор данснаас хассан хөрөнгөтэй холбоотой мэдээлэл алдаатай буруу тодорхойлогдож байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгөв.

Асуудал 6 Хүүхдийн цэцэрлэг: Жилийн эцэст 2780.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоов.

Асуудал 7 Хүүхдийн цэцэрлэг: Бараа материалын тайланг нэр төрөл, үнийн дүнгээр тайлагнаагүй, нийт дүнгээр тайлагнасан байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгөв.

Асуудал 8 Засаг даргын тамгын газар: Нийгмийн даатгалын тайлан болон санхүүгийн байдлын тайлангаар НДШ-ийн 2091.4 мянган төгрөгийн авлагатай байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоов.

Асуудал 9 Засаг даргын тамгын газар: Бараа материалын тайланг нэр төрөл, үнийн дүнгээр тайлагнаагүй, нийт дүнгээр тайлагнасан байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгөв.

Асуудал 10 Иргэдийн Төлөөлөгчдийн хурал: Бараа материалын тайланг нэр төрөл, үнийн дүнгээр тайлагнаагүй, нийт дүнгээр тайлагнасан байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгөв.

## 2. Зардлын данстай холбоотой асуудал:

**Асуудал 11** Сургууль: Цалингийн хүснэгтээс харахад Төсвийн шууд захирагчид 133.2 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоов.

## 3. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

**Асуудал 12** Сургууль: Тухайн байгууллагын батлагдсан төсвөөс харахад Тавилга, урсгал зардал, хичээл үйлдвэрлэлийн зардлын хувьд 42,990.5 мянган төгрөгийн худалдан авалтыг хийхдээ төрийн болон орон нутгийн өмчөөр бүтээгдэхүүн ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй, [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад байршуулж нийтэд мэдээлээгүй байна.

**Шийдэл:** Албан шаардлага бичив.

**Асуудал 13** Соёлын төв: 2018 оны санхүүгийн баримтаас харахад төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа зарим гүйлгээний хувьд хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллаагүй байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгөв.

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	36,200.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	36,200.0	

### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд орууллаа.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрдэнэ сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 6 хөтөлбөр, 24 арга хэмжээнд зориулан 1,686,159.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1,703,849.6 мянган төгрөг буюу 101.0 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1,681,447.1 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь СХС-ийн зээлийн эргэн төлөлт, нөхөн сэргээлтийн сангийн барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлтээс шалтгаалжээ.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл :

Байгууллагын нэр	ИТХ-аас баталсан төлөвлөгөө	Орлого, сан, байгууллагын гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
<b>Орлого:</b>	<b>1,686,159,400.00</b>	<b>1,703,849,578.47</b>		
Татварын орлого	81,499,900.00	84,700,104.47	-3,200,204.47	
Татварын бус орлого	1,500,000.00	672,360.00	827,640.00	
Санхүүгийн дэмжлэг	330,946,900.00	330,946,900.00	0.00	
Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	83,415,280.00	83,415,280.00	0.00	
Тусгай зориулалтын шилжүүлэг	1,113,904,900.00	1,113,904,900.00	0.00	
Сум хөгжүүлэх сан			-	

	46,500,000.00	59,463,034.00	12,963,034.00	
Нөхөн сэргээлтийн сан	24,815,000.00	28,890,000.00	-4,075,000.00	
Өөрийн орлого /Соёлын төв/	1,857,000.00	1,857,000.00	0.00	
эхний үлдэгдлээс ОНХС	1,720,420.00			
<b>Зарлага:</b>	<b>1,686,159,400.00</b>	<b>1,681,447,119.00</b>	4,712,281.00	
ЗДТГ	365,404,300.00	365,404,300.00	0.00	
ИТХ	48,542,500.00	48,542,500.00	0.00	
Сургууль	601,152,600.00	601,152,600.00	0.00	
Цэцэрлэг	190,607,800.00	190,607,800.00	0.00	
Соёлын төв	67,498,000.00	67,498,000.00	0.00	
ЭМТ	256,503,500.00	256,503,500.00	0.00	
Орон нутгийн хөгжлийн сан	85,135,700.00	84,898,609.00	237,091.00	Эхний үлдэгдэл тодотгуулсан 1720420
Сум хөгжүүлэх сан	46,500,000.00	49,176,800.00	-2,676,800.00	эхний үлдэгдлээс санхүүжсэн
Нөхөн сэргээлтийн сан	24,815,000.00	17,663,010.00	7,151,990.00	

## 2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэ сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

## 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн 127.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийн 7.5 хувь буюу 9.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 10.1 хувь буюу 12.8 сая төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 53.8 хувь буюу 68.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 28.6 хувь буюу 36.4 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	5	36200.0			5	36200.0	0	0
2	ТШЗ	13	81428.8	2	9534.0	15	90962.8	2	9534.0
3	ТБӨӨААН								
	Дүн	18	117628.8	2	9534.0	20	127162.8	2	9534.0

### Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	5	36200.0	0	0	0	0	5	36200.0	0	0	0	0
2	ТШЗ	13	81428.8	4	12811.3	2	68459.1	7	158.4	0	0	0	0
3	ТБӨӨААН												
	Дүн	18	117628.8	4	12811.3	2	68459.1	12	36358.4	0	0	0	0

## 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэ сумын Засаг дарга 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

**Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)**

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)			Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	
1	ТШЗ	4	1		5
2	ТБӨААН				
	Дүн	4	1		5

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрдэнэ сумын Засаг дарга нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

##### **3.1.1. Илрүүлэлт: Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

1. Сумын ИТХ-аас СХС-ийн төлөвлөгөөг 46500.0 мянган төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 55724.4 мянган төгрөгийн үндсэн зээл, 3738.6 мянган төгрөгийн зээлийн хүүгийн орлого орсон ба 5 хүнд 49.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Төлөвлөснөөс зээлийн төлөлт, 9.2 сая төгрөг, зээл олголт 2.5 сая төгрөгөөр илүү байна. Зээлийн төлөлтийн тухайн онд төлөгдөх тооцооллыг хийж төсөв батлуулаагүй байна.

2. Байгаль хамгаалах, Нөхөн сэргээлтийн сангийн зарлагын төсвийг 24.8 сая төгрөгөөр, Сум хөгжүүлэх сангийн зарлагын төсвийг 46.5 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр БХНСС-аас 28.9 сая төгрөгийн зарлага гаргаж 4.1 сая төгрөгөөр, СХС-аас 59.4 сая төгрөгийн зарлага гаргаж 12.9 сая төгрөгөөр тус тус төсөв хэтрүүлсэн байна.

Энэ нь үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5.1."Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална" 5.1.2.-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх**

**3.1.3. Өгсөн зөвлөмж:** СХС, Нөхөн сэргээлтийн сангийн төсвийг тооцоо, судалгаанд үндэслэж төлөвлөх

### **3.2.1. Илрүүлэлт: Балансын данстай холбоотой асуудал**

3.Нөхөн сэргээлтийн сан дансанд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй компани, иргэдийн нөхөрлөлөөс үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчныг нөхөн сэргээхээр байршуулсан нийт 19.2 сая төгрөгийн хөрөнгийг тайлант хугацааны үр дүнгээр тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" зарчмыг тус тус зөрчсөн байна.

**3.2.2. Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

**3.2.3. Өгсөн зөвлөмж:** Барьцаа хөрөнгийг өр төлбөр дансанд бүртгэх

### **3.3.1. Илрүүлэлт: Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт**

4.СХС-ийн харилцах дансны журнал болон авлагын журнал хөтлөөгүй байна. Зээлдэгчдийн эргэн төлөлтийг өссөн дүнгээр тайлагнасан нь тухайн тайлант хугацааны зээлийн төлөлт, хүү, алдангийн тооцоог харах боломжгүй болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 4.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх;14.3.2.журналд бичих; 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах гэсэн заалттай нийцэхгүй байна.

**3.3.2. Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

**3.3.3. Өгсөн зөвлөмж:** Мөнгөн хөрөнгийн журнал, авлагын журнал хөтлөх

### **3.4.1. Илрүүлэлт: Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн**

5.Тайлант онд хугацаа хэтэрсэн зээлдэгч нарт Засаг даргын албан бичиг хүргүүлж биечлэн уулзаж 6 иргэний 5.0 сая төгрөг, 3 иргэний зээлийг бүрэн хаалгасан байна. Бусад зээлдэгчдийн зээлийг төлж барагдуулахаар баталгаа гаргуулж авсан байна. Тайлант хугацааны эцэст хугацаа хэтэрсэн буюу 2013 онд олгосон 6 хүний 11.5 сая төгрөг, 2014 онд зээл олгосон 1 хүний 20.4 сая төгрөг, 2015 онд зээл олгосон 4 хүний 29.9 сая төгрөгийн нийт 11 хүний 61.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байна. Энэ нь 5.3.2.-т "сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх" гэсэн заалтыг зөрчиж байна.

**3.2.2. Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

**3.2.3. Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019.06.25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>446,403,110.93</b>	<b>537,734,680.96</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>37,259,836.80</b>	<b>60,004,011.80</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	37,259,836.80	60,004,011.80
31210	Төгрөг	37,259,836.80	60,004,011.80
31211	Төрийн сангийн харилцах	37,259,836.80	60,004,011.80
33	<b>АВЛАГА</b>	<b>170,722,628.78</b>	<b>198,811,494.42</b>
33500	<b>Бусад авлага</b>	<b>6,458,088.78</b>	<b>44,351,290.42</b>
33510	Байгууллагаас авах авлага	6,341,766.78	44,351,290.42
33520	Хувь хүмүүсээс авах авлага	116,322.00	0.00
33600	<b>Зээлийн авлага</b>	<b>164,222,540.00</b>	<b>154,460,204.00</b>
33610	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>164,222,540.00</b>	<b>154,460,204.00</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	164,222,540.00	154,460,204.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>237,281,645.35</b>	<b>277,780,174.74</b>
35100	<b>Түүхий эд материал</b>	<b>63,781,054.75</b>	<b>71,340,512.91</b>
35110	Тусгай зориулалттай материал	63,333,891.43	70,790,505.35
35130	Эм боох материал	447,163.32	550,007.56
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>171,365,590.60</b>	<b>204,119,661.83</b>
35410	Бичиг хэргийн материал	9,332,976.00	10,202,518.00
35420	Аж ахуйн материал	16,326,194.00	19,345,581.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,360,000.00	3,360,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,295,340.00	1,326,680.00
35450	Барилгын засварын материал	40,000.00	7,807,000.00
35460	Хүнсний материал	7,434,531.80	6,029,548.28
35470	Бусад хангамжийн материал	130,576,548.80	156,048,334.55
35600	Мал амьтад	2,135,000.00	2,320,000.00
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>1,139,000.00</b>	<b>1,139,000.00</b>
36300	Тэжээлийн нөөц	1,139,000.00	1,139,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,153,657,905.31</b>	<b>2,680,410,898.93</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,153,657,905.31</b>	<b>2,680,410,898.93</b>
39100	Газар	0.00	0.00
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,153,057,072.18</b>	<b>2,543,397,898.97</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,059,679,441.33	1,483,247,037.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-459,094,896.69	-11,433,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	269,407,304.00	260,097,304.00

39204	Хуримтлагдсан элэгдэл	-153,083,094.74	-178,470,504.54
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	387,347,588.82	423,162,790.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-248,597,887.51	-283,555,059.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	128,275,144.30	158,529,921.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,882,505.65	-69,336,677.63
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	158,170.00	158,170.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	298,259,690.12	1,011,199,072.45
39215	Хуримтлагдсан элэгдэл	-80,973,909.38	-266,222,182.36
39217	Ном	14,562,027.58	16,021,027.58
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>600,833.13</b>	<b>137,012,999.96</b>
39301	Програм хангамж	1,925,000.00	115,533,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,520,000.04	-1,670,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө	400,000.00	23,550,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-204,166.83	-400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,600,061,016.24</b>	<b>3,218,145,579.89</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,108,442.29</b>	<b>2,714,280.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,108,442.29</b>	<b>2,714,280.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>6,108,442.29</b>	<b>2,714,280.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,138,200.14	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,101,714.00	0.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>2,868,528.15</b>	<b>2,714,280.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	944,401.15	2,714,280.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,924,127.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,593,952,573.95</b>	<b>3,215,431,299.89</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,593,952,573.95</b>	<b>3,215,431,299.89</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,642,351,573.55	1,686,425,573.55
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	92,684,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,431,215,959.86</b>	<b>1,326,791,148.30</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,359,128,439.11	1,428,001,123.86
51220	Тайлант үеийн үр дүн	72,087,520.75	-101,209,975.56
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
